# НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

**Нийслэлийн Аудитын газар Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт, холбогдох хууль, журам зааврыг баримтлан хийлээ.**

**Лавлах зүйл байвал 325093-1114 дугаарын утаснаас лавлана уу?**

**Т.Сарантуяа**
**Нийслэлийн Аудитын газрын дэд дарга**
**өрөөний утас: 327734**

**Ц.Хосжаргал**
**Аудитын менежер**
**өрөөний утас: 315558**

**В.Эрдэнэцогт**
**Ахлах аудитор**

**Б.Мөнхбат**
**Аудитор**
**өрөөний утас: 325093-1114**

**Хаяг:**

**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ж.Лхагвасүрэнгийн гудамж Нийслэлийн засаг захиргааны V байр**

**E-mail:** ub@audit.mn

**Вэб сайт:** http://city.audit.mn

| **АГУУЛГА** | **ХУУДАС** |
|---|---|


- Товчилсон үгийн тайлбар.................... 2
- Аудит дуусгавар болсон тухай.......... 3-4
- Танилцуулга ................................ 5
- Санхүүгийн дотоод хяналт ............ 5-6
- Гол шийдлүүд ....... ...................... 6
- Залруулаагүй алдаа ...................... 6
- Тайлбар мэдүүлгийн захидал............ 6
- Аудитын санал дүгнэлт .................. 6-7
- Менежментийн захидлын хариу ........ 8
- Аудитлагдсан санхүүгийн тайлан ...... 9-15

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| НАГ | Нийслэлийн Аудитын газар |
| НТЗАБ | Нийслэлийн төр захиргааны автобааз |
| НАЖГ | Нийслэлийн аялал жуулчлалын газар |
| ТТХ | Төсвийн тухай хууль |

# Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Нийслэлийн Аудитын газраас аудит хийж дуусгавар болгосон тухай тайлан

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж дууссан тухай тайланг байгууллагын удирдлагад танилцуулж байна.

Менежментийн захидалд санхүүгийн хяналтыг сайжруулахаар өгсөн зөвлөмжийг хүргүүлж, Нийслэлийн Аялал жуулчлалын газраас хариу ирүүлснийг энэхүү тайланд багцлан тусгасан болно.

Байгууллагын удирдлагын анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- ***Санхүүгийн гол хяналтууд***:

Төсвийн хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагаанд Нийслэлийн Төрийн сангийн хэлтсээс зохих хяналтыг хэрэгжүүлж байна. НББ-ийн тайлагналын үе шат бүрд түүнчлэн УСНББОУС болон Сангийн сайдын 2005 оны 276, 2006 оны 388, 2011 оны 48, 2013 оны 76, 269 дүгээр тушаалаар баталсан журам, зааврууд, төсвийн хөрөнгийг захиран зарцуулах, хөрөнгө бэлтгэх, данс бүртгэлээс хасах, данс бүртгэлд тусгахад мөрдөж буй стандарт журам, заавар, дээд шатны удирдлагаас хэрэгжүүлж байгаа хяналтыг авч үзлээ.

- ***Санхүүгийн гол эрсдлүүд:***

Дотоод хяналтын системыг үнэлэхэд доор дурьдсан эрсдэлүүд гарах магадлалтай байна Үүнд:

1. НББ-ийн дансны бичилт буруу хийсэн байх. Э-9 /Толилуулга ба илчлэл/
2. Баримтыг бүрэн бүрдүүлэлгүй орлого, зарлагыг хүлээн зөвшөөрсөн байх. Э-10 /Иж бүрэн байх, Үнэн зөв байдал/
3. Холбогдох стандарт, хууль, тогтоомж зөрчсөн байх. Э-14 /Үнэн зөв байдал/
4. Байгууллагын хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэр, орлого, зардлыг санхүүгийн тайланд бүрэн, үнэн зөв тусгаагүй байх. Э-1 /Иж бүрэн байх, Эрх ба үүрэг, толилуулага ба илчлэл/

Эдгээр эрсдэлүүд байгаа эсэхийг нотлох үүднээс аудитыг төлөвлөн аудитын холбогдох горимуудыг хэрэгжүүлэхэд дээрх батламж мэдэгдэл хангахгүй зөрчил байна.

***Аудитаар илрүүлсэн гол зүйлсийн талаар тодруулвал:***

773.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 773.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тооцсон хүлээн зөвшөөрөх түвшинээс бага байгааг үндэслэн Зөрчилгүй - санал дүгнэлт өгч байна.

Нийслэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурлаа.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ажилтнуудын байнгын туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**Нийслэлийн Аудитын газар**

**2014-03-24.**

## Танилцуулга

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж дууссан тухай тайланг удирдлагад танилцуулж байна. Өмнө нь хүргүүлсэн Менежментийн захидалд санхүүгийн хяналтыг сайжруулахаар бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд удирдлага аудитаар илэрсэн асуудал, зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн байна.

Аудитор аудитад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үйл ажиллагааг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдэлийг тооцож аудитыг төлөвлөж, холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай аудитын горимуудыг дансдаас түүвэрлэж хэрэгжүүлэв.

Аудитад Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон тэдгээрийн гүйцэтгэлийг хамруулсан болно.

Монгол Улсын төсвийн байгууллагуудад мөрдүүлж байгаа Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын заавар, журам нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын заримтай нийцэхгүй байна. Тухайлбал: Төсвийн байгууллагууд санхүүгийн тайлангаа аккруэл сууриар бус, аккруэл-мөнгө хольсон сууриар тайлагнаж байхаар журамласан нь авлага, өглөг, хөрөнгө, тайлант үеийн орлого, зардал, үр дүнгийн үзүүлэлтүүд олон улсын стандартаас зөрүүтэй илэрхийлэгдэх магадлалтай.

Сангийн яамнаас нэгэнт бүх төсөвт байгууллагуудад дээрх заавар журмыг мөрдүүлсэн учраас санхүүгийн тайланг түүнтэй нийцүүлэн аудит хийв.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн сул талууд, түүнийг хэрхэн шийдвэрлэснийг дахин шалгах зэрэг ажлуудыг хийлээ.

Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн тайлангаар гарсан зөрчлүүдийг дараах асуудлуудад хураангуйлсан.

### Нэг: Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

1. Аудитор санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хяналаа. Ийнхүү хянахдаа Нийслэлийн Аялал жуулчлалын газрын хэрэгжүүлж буй дотоод хяналтыг НАГ-аас тооцож гаргасан санхүүгийн эрсдэл ба хяналтын байвал зохих горимтой харьцуулан шалгаж үзсэн. Үүний үр дүнд удирдлагаас зайлшгүй хэрэгжүүлэх дотоод хяналт ямар байгааг тогтоосон. Аудитор байгууллагын удирдлагад бүртгэл санхүүгийн үйл ажиллагаа, тайлагнал, дотоод хяналтад илэрсэн сул талуудыг тухай бүрд нь мэдэгдэж ажиллаа.
2. Санхүүгийн тайлангаар илэрсэн гол зөрчлүүдийг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын анхааралд хандуулж байна. Үүнд:

***1 дүгээр асуудал:***

- ✓ Тус байгууллага нь оны эцэст төсвийн хэмнэлттэй гарсан байтал тээврийн зардлын төлбөрийг барагдуулаагүй нь харилцагч

байгууллагуудтайгаа цаг тухайд нь тооцоо нийлдэггүйтэй холбоотой байна

**Хоёр: Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд**

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Санхүүгийн тайлангын аудитаар 773.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

**Зарим хууль, тогтоомж, заавар журам зөрчсөн 773.0 мянган төгрөгийн зөрчил илрэв.**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4. "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" заалтыг хэрэгжүүлээгүйгээс оны эцэст тээврийн зардлын төсөв хэмнэлттэй байхад 773.0 мянган төгрөгийн тээврийн зардлын төлбөрийг барагдуулаагүй өглөг төлбөр үүсгэсэн.

- Харилцагч байгууллагуудтай цаг тухайд нь тооцоо нийлж, баталгаажуулж байх зөвлөмж өглөө.

**Гурав: Залруулагдаагүй алдаа**

Аудитын стандарт нь аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Эдгээр залруулагдаагүй алдаануудад байгууллагын удирдлага анхаарлаа *хандуулж шийдвэрлэх* шаардлагатай. Үүнд: Тайланд илэрсэн залруулагдаагүй 773.0 мянган төгрөгийн зөрчлийг байгууллагын удирдлага цаашид давтан гаргахгүй ажиллах нь зүйтэй байна.

***Дөрөв: Тайлбар мэдүүлгийн захидал***

Нийслэлийн аудитын газар аудит хийхдээ Нийслэлийн Аялал жуулчлалын газрын удирдлагын зүгээс гаргасан санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлд тулгуурлав.

Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар тухайн байгууллагын санхүүгийн ажилтнуудаас тайлбар тодруулга авч бэлтгэсэн менежментийн захидлыг 2014 оны 3 дугаар сарын 20-ний өдрийн 442 тоотоор Нийслэлийн Аялал жуулчлалын газарт хүргүүлж, менежментийн захидалд дурдсан зөрчлийг хүлээн зөвшөөрсөн хариуг 2014 оны 3 дугаар сарын 24-ны 96 тоот бичгээр ирүүлснийг хавсаргав.

**Тав: Аудитын санал дүгнэлт**

Нийслэлийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31–нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд илэрсэн 773.0 мянган төгрөгийн

зөрчил нь хүлээн зөвшөөрөх түвшинээс бага байгааг үндэслэн Зөрчилгүй-санал дүгнэлт өгч байна.

**Нийслэлийн Аудитын газар**
**Огноо 2014-03-24.**

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 13, Сэнбүүгийн гудамж, Нийслэлийн засаг захиргааны IV байр
Утас: 7013-6887, Факс: (976) 7012 6887
http://www.tourism.ub.gov.mn
E-mail: info@tourism.ub.gov.mn

2014.03.24. № 96

Таны ________ -ны № ________ -т

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус газрын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсний дагуу менежментийн захидалтай танилцлаа. Цаашид санхүүгийн аудитаар өгсөн заавар зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ДАРГА Э.БАТТУЛГА

Т. Сарантуяа

Ц. Оюун

24/III

115500155

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
/төгрөгөөр/

| БАЛАНСЫН ЗҮЙЛ | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | |
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | 26,475,784.42 | 5,257,349.01 |
| **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 20,187,185.42 | 1,000.01 |
| Кассанд байгаа бэлэн мөнгө | 2,718.18 | 1,000.00 |
| Төгрөг\ ЖМС | 2,718.18 | 1,000.00 |
| Банкинд байгаа бэлэн мөнгө | 20,184,467.24 | 0.01 |
| Төгрөг | 20,184,467.24 | 0.01 |
| Орон нутгийн харилцах | 20,184,467.24 | 0.01 |
| **БАРАА МАТЕРИАЛ** | 6,288,599.00 | 5,256,349.00 |
| Түүхий эд материал | 249,000.00 | 249,000.00 |
| Тусгай зориулалттай материал | 249,000.00 | 249,000.00 |
| Хангамжийн материал | 6,039,599.00 | 5,007,349.00 |
| Бичиг хэргийн материал | 5,673,268.00 | 3,419,525.00 |
| Аж ахуйн материал | 11,951.00 | 1,233,444.00 |
| Бусад ( хуучин: Бусад хангамжийн материал) | 354,380.00 | 354,380.00 |
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 26,475,784.42 | 5,257,349.01 |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ** | 21,748,020.64 | 29,927,485.93 |
| **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 21,748,020.64 | 29,927,485.93 |
| Биет хөрөнгө | 20,682,187.36 | 29,251,652.65 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 8,292,693.55 | 10,592,715.64 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг | 24,622,556.00 | 32,729,546.00 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл | (16,329,862.45) | (22,136,830.36) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,389,493.81 | 15,858,937.01 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг | 20,249,900.00 | 26,022,400.00 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл | (7,860,406.19) | (10,163,462.99) |
| Бусад үндсэн хөрөнгө | - | 2,800,000.00 |
| Бусад үндсэн хөрөнгө | - | 3,000,000.00 |
| Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл | - | (200,000.00) |
| Биет бус хөрөнгө | 1,065,833.28 | 675,833.28 |
| Програм хангамж | 1,065,833.28 | 675,833.28 |
| Програм хангамж - Анхны өртөг | 1,950,000.00 | 1,950,000.00 |
| Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл | (884,166.72) | (1,274,166.72) |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 21,748,020.64 | 29,927,485.93 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **48,223,805.06** | **35,184,834.94** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 773,020.00 |
| өглөг | - | 773,020.00 |
| Бараа үйлчилгээний зардлын тооцоо | - | 773,020.00 |
| Тээвэр, шатахууны тооцоо | - | 773,020.00 |
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | - | 773,020.00 |

| | | |
|---|---|---|
| **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | - | 773,020.00 |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧ** | - | - |
| Засгийн газрын сан | 60,000,000.00 | 60,000,000.00 |
| Хуримтлагдсан үр дүн | (11,776,194.94) | (25,588,185.06) |
| Өмнөх үеийн үр дүн | (11,776,194.94) | (11,776,194.94) |
| Тайлант үеийн үр дүн | - | (13,811,990.12) |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН** | 48,223,805.06 | 34,411,814.94 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН** | 48,223,805.06 | 35,184,834.94 |

## АУДИТЛАГДСАН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх он | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО** | | |
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 172,950,500.00 | 222,757,500.00 |
| Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт | 172,950,500.00 | 222,757,500.00 |
| Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг | 172,950,500.00 | 222,757,500.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 154,950,500.00 | 222,757,500.00 |
| Хөрөнгийн | 18,000,000.00 | - |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 7,404,802.02 | 30,751,257.26 |
| Бараа, үйлчилгээний борлуулалт | 7,404,802.02 | 30,751,257.26 |
| Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого | 7,404,802.02 | 30,751,257.26 |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 7,404,802.02 | 30,751,257.26 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | 180,355,302.02 | 253,508,757.26 |
| **АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ** | 78,408,126.35 | 124,437,806.21 |
| Үндсэн болон нэмэгдэл цалин | 70,332,809.00 | 111,544,231.00 |
| Үндсэн цалин | 64,832,109.00 | 88,914,433.00 |
| Нэмэгдэл цалин | - | 11,009,998.00 |
| Унаа, хоолны хөнгөлөлт | 5,500,700.00 | 11,619,800.00 |
| Нийгмийн хамгааллын шимтгэл | 8,075,317.35 | 12,893,575.21 |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 6,649,196.65 | 10,602,931.21 |
| Тэтгэврийн даатгалын шимтгэл | 5,207,635.95 | 8,282,023.00 |
| Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 371,975.42 | 946,519.21 |
| ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 713,054.85 | 1,145,324.00 |
| Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 356,530.43 | 229,065.00 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 1,426,120.70 | 2,290,644.00 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 77,362,314.15 | 105,834,960.27 |
| Бараа үйлчилгээний урсгал зардал | 66,062,890.20 | 72,983,930.27 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 66,062,890.20 | 72,983,930.27 |
| Бичиг хэргийн зардал | 7,266,882.00 | 5,912,043.00 |
| Тээвэр, шатахуун | 4,809,000.00 | 8,316,059.00 |
| Шуудан, харилцаа холбоо | 3,321,002.25 | 4,686,167.36 |
| Дотоод албан томилолт | 1,000,000.00 | 881,600.00 |

| | | |
|---|---|---|
| Ном, хэвлэл захиалах, худалдан авах | 168,300.00 | 167,130.00 |
| Хичээл, үйлдвэрлэлийн дадлага | 890,000.00 | 995,000.00 |
| Төлбөр хураамж, жижиг татварууд | 9,624,780.00 | 5,793,772.20 |
| Харуул, хамгаалалтын зардал | 3,720,000.00 | - |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 22,982,758.00 | 11,266,999.00 |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ | 22,982,758.00 | 11,266,999.00 |
| Маягт хэвлүүлэх зардал | - | 4,051,135.00 |
| Урсгал засвар | 2,000,000.00 | 22,214,000.00 |
| Холбооны шугам ашигласны зардал | 2,484,000.00 | - |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 7,796,167.95 | 8,700,024.71 |
| Хөтөлбөр арга хэмжээний зардал | 11,299,423.95 | 32,851,030.00 |
| Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал | 4,583,650.00 | 30,851,030.00 |
| Мэдээлэл, сурталчилгааны ажил (гадаад, дотоод) | - | 5,216,230.00 |
| Бусад төвлөрсөн арга хэмжээ | 4,583,650.00 | 25,634,800.00 |
| Засгийн газрын нөөц хөрөнгө /Орон нутгийн нөөц хөрөнгө/ | 6,715,773.95 | - |
| Бусад төсөл арга хэмжээ | 6,715,773.95 | - |
| Бусад | 6,715,773.95 | - |
| Төсвийн хуваарилагдаагүй зардал | - | 2,000,000.00 |
| Бусад төсөл арга хэмжээ | - | 2,000,000.00 |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ** | 18,000,000.00 | - |
| Хөрөнгө оруулалт | 18,000,000.00 | - |
| Дотоод эх үүсвэрээс | 18,000,000.00 | - |
| Орон нутгийн хөрөнгөөр санхүүжих | 18,000,000.00 | - |
| **ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГА, НЭГЖҮҮДЭД ОЛГОСОН** | - | 28,526,502.90 |
| Төсвийн ерөнхийлөн захирагчидад олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 28,526,502.90 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 28,526,502.90 |
| **НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ** | 1,500,000.00 | 8,521,478.00 |
| **Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж** | 1,500,000.00 | 8,521,478.00 |
| Мөнгөн хэлбэрээр | 1,500,000.00 | 8,521,478.00 |
| Нэг удаагийн тэтгэмж | 1,500,000.00 | 8,521,478.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 175,270,440.50 | 267,320,747.38 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | 5,084,861.52 | (13,811,990.12) |
| **Бусад зардал ба алдагдал** | 53,250,000.00 | - |
| Хөрөнгийн худалдсаны гарз | 53,250,000.00 | - |
| Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 53,250,000.00 | - |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 53,250,000.00 | - |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **(48,165,138.48)** | **(13,811,990.12)** |

## АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх он | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 178,965,419.00 | 223,815,005.00 |
| Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт | 178,965,419.00 | 223,815,005.00 |
| Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг | 172,950,500.00 | 222,757,500.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 154,950,500.00 | 222,757,500.00 |
| Хөрөнгийн | 18,000,000.00 | - |
| Төсөвт байгууллагаас | 4,588,650.00 | - |
| ТЕЗ-аас олгосон санхүүжилт | 4,588,650.00 | - |
| Нийгмийн даатгалын сангаас | 1,426,269.00 | 1,057,505.00 |
| НДС-ийн шилжүүлэг | 1,426,269.00 | 1,057,505.00 |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 4,696,152.02 | 30,751,257.26 |
| Бараа, үйлчилгээний борлуулалт | 4,696,152.02 | 30,751,257.26 |
| Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого | 4,696,152.02 | 30,751,257.26 |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 4,696,152.02 | 30,751,257.26 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | 183,661,571.02 | 254,566,262.26 |
| **АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ** | 78,408,126.35 | 124,437,806.21 |
| Үндсэн болон нэмэгдэл цалин | 70,332,805.00 | 111,544,234.10 |
| Үндсэн цалин | 57,110,540.00 | 85,058,560.10 |
| Бусад нэмэгдлүүд | 7,721,565.00 | 14,865,874.00 |
| Бусад нэмэгдэл | 7,721,565.00 | 14,865,874.00 |
| Унаа, хоолны хөнгөлөлт | 5,500,700.00 | 11,619,800.00 |
| Нийгмийн хамгааллын шимтгэл | 8,075,321.35 | 12,893,572.11 |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 6,649,196.66 | 10,602,929.89 |
| Тэтгэврийн даатгалын шимтгэл | 5,207,635.95 | 8,282,022.67 |
| Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 371,975.43 | 939,421.89 |
| ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 713,054.85 | 1,145,322.61 |
| Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 356,530.43 | 236,162.72 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 1,426,124.69 | 2,290,642.22 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 69,255,764.20 | 95,380,675.56 |
| Бараа үйлчилгээний урсгал зардал | 55,472,340.25 | 62,154,635.56 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 55,472,340.25 | 62,154,635.56 |
| Бичиг хэргийн зардал | 5,993,000.00 | 6,731,930.00 |
| Тээвэр, шатахуун | 4,809,000.00 | 7,493,539.00 |
| Шуудан, харилцаа холбоо | 3,183,002.25 | 4,495,667.36 |
| Дотоод албан томилолт | 1,000,000.00 | 881,600.00 |
| Ном, хэвлэл захиалах, худалдан авах | 188,300.00 | 167,130.00 |
| Хичээл, үйлдвэрлэлийн дадлага | 890,000.00 | 995,000.00 |
| Жижиг эд хогшил худалдан авах | - | 659,998.00 |
| Багаж хэрэгсэл худалдан авах | - | 659,998.00 |
| Төлбөр хураамж, жижиг татварууд | 9,624,780.00 | 5,465,772.20 |
| Харуул, хамгаалалтын зардал | 3,720,000.00 | - |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 24,064,258.00 | 12,199,999.00 |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ | 24,064,258.00 | 12,199,999.00 |

| | | |
|---|---|---|
| Маягт хэвлүүлэх зардал | - | 850,000.00 |
| Урсгал засвар | 2,000,000.00 | 22,214,000.00 |
| Хөтөлбөр арга хэмжээний зардал | 13,783,423.95 | 33,226,040.00 |
| Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал | 4,583,650.00 | 33,226,040.00 |
| УИХ болон ИТХ-д суудалтай намд олгох санхүүгийн дэмжлэг | - | 5,216,230.00 |
| Бусад төвлөрсөн арга хэмжээ | 4,583,650.00 | 27,634,800.00 |
| Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт | - | 375,010.00 |
| Засгийн газрын нөөц хөрөнгө /Орон нутгийн нөөц хөрөнгө/ | 2,484,000.00 | - |
| Бусад төсөл арга хэмжээ | 2,484,000.00 | - |
| Бусад | 2,484,000.00 | - |
| Төсвийн хуваарилагдаагүй зардал | 6,715,773.95 | - |
| бусад нэр төрлийн хувиарлагдаагүй зардал | 6,715,773.95 | - |
| **ХөРөНГө ОРУУЛАЛТ, ҮНДСЭН ХөРөНГИЙН АШИГЛАЛТ** | 18,000,000.00 | - |
| Хөрөнгө оруулалт | 18,000,000.00 | - |
| Дотоод эх үүсвэрээс | 18,000,000.00 | - |
| Орон нутгийн хөрөнгөөр санхүүжих | 18,000,000.00 | - |
| **ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГА, НЭГЖҮҮДЭД ОЛГОСОН** | - | 28,526,502.90 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 28,526,502.90 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 28,526,502.90 |
| **НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ** | 2,926,269.00 | 9,527,973.00 |
| **Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж** | 2,926,269.00 | 9,527,973.00 |
| Мөнгөн хэлбэрээр | 2,926,269.00 | 9,527,973.00 |
| Нэг удаагийн тэтгэмж | 1,500,000.00 | 8,470,468.00 |
| Бусад | 1,426,269.00 | 1,057,505.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН** | 168,590,159.55 | 257,872,957.67 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 15,071,411.47 | (3,306,695.41) |
| Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал | 1,600,000.00 | 16,879,490.00 |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН** | 1,600,000.00 | 16,879,490.00 |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | (1,600,000.00) | (16,879,490.00) |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 13,471,411.47 | (20,186,185.41) |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 6,715,773.95 | 20,187,185.42 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 20,187,185.42 | 1,000.01 |

## АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2012 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 60,000,000.00 | - | (11,776,194.94) | 48,223,805.06 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Тайлант үеийн үр дүн | - | - | (13,811,990.12) | (13,811,990.12) |
| **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 60,000,000.00 | - | (25,588,185.06) | 34,411,814.94 |

## АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| д/д | Эдийн засгийн ангилал | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | | | /+илүү, -дутуу/ | Хувь |
| 1 | I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V) | 225,672,000.00 | 214,528,639.77 | (11,143,360.23) | -4.9 |
| 2 | II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV) | 225,672,000.00 | 214,528,639.77 | (11,143,360.23) | -4.9 |
| 3 | III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 225,672,000.00 | 214,528,639.77 | (11,143,360.23) | -4.9 |
| 4 | Бараа ажил үйлчилгээний зардал | 225,672,000.00 | 214,528,639.77 | (11,143,360.23) | -4.9 |
| 5 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 134,604,600.00 | 124,437,806.21 | (10,166,793.79) | -7.6 |
| 6 | Үндсэн цалин | 108,751,300.00 | 99,924,434.10 | (8,826,865.90) | -8.1 |
| 7 | Гэрээт ажлын цалин | - | - | - | - |
| 8 | Хоол унааны хөнгөлөлт | 12,514,200.00 | 11,619,800.00 | (894,400.00) | -7.1 |
| 9 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 13,339,100.00 | 12,893,572.11 | (445,527.89) | -3.3 |
| 10 | Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл | 10,913,800.00 | 10,602,929.89 | (310,870.11) | -2.8 |
| 11 | Тэтгэврийн даатгал | 8,488,600.00 | 8,282,022.67 | (206,577.33) | -2.4 |
| 12 | Тэтгэмжийн даатгал | 970,100.00 | 939,421.89 | (30,678.11) | -3.2 |
| 13 | ҮОМШ өвчний даатгал | 1,212,600.00 | 1,145,322.61 | (67,277.39) | -5.5 |
| 14 | Ажилгүйдлын даатгал | 242,500.00 | 236,162.72 | (6,337.28) | -2.6 |
| 15 | Байгууллага төлөх ЭМД-ын хураамж | 2,425,300.00 | 2,290,642.22 | (134,657.78) | -5.6 |
| 16 | Бараа ,үйлчилгээний урсгал зардал | 91,067,400.00 | 90,090,833.56 | (976,566.44) | -1.1 |
| 17 | Бичиг хэргийн материал | 6,920,000.00 | 6,731,930.00 | (188,070.00) | -2.7 |
| 18 | Тээвэр, шатахууны зардал | 8,050,000.00 | 7,493,539.00 | (556,461.00) | -6.9 |
| 19 | Шуудан холбооны зардал | 4,500,000.00 | 4,495,667.36 | (4,332.64) | -0.1 |
| 20 | Дотоод томилолтын зардал | 1,000,000.00 | 881,600.00 | (118,400.00) | -11.8 |
| 21 | Гадаад томилолтын зардал | - | - | - | - |
| 22 | Ном , хэвлэлийн зардал | 200,000.00 | 167,130.00 | (32,870.00) | -16.4 |
| 23 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 1,000,000.00 | 995,000.00 | (5,000.00) | -0.5 |
| 24 | Сургалт семинарын зардал | 5,220,000.00 | 5,216,230.00 | (3,770.00) | -0.1 |
| 25 | Эрдэм шинжилгээний ажлын зардал | - | - | - | - |
| 26 | Жижиг эд хогшил худалдан авах зардал | 12,000,000.00 | 11,999,998.00 | (2.00) | 0.0 |
| 27 | Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах | - | - | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зардал | | | | |
| 28 | Төлбөр, хураамж, жижиг татварууд | 5,500,000.00 | 5,465,772.20 | (34,227.80) | -0.6 |
| 29 | Харуул, хамгаалалтын зардал | - | - | - | - |
| 30 | Банкны үйлчилгээний хураамж | - | - | - | - |
| 31 | Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 12,200,000.00 | 12,199,999.00 | (1.00) | 0.0 |
| 32 | Маягт хэвлүүлэх зардал | 850,000.00 | 850,000.00 | - | 0.0 |
| 33 | Урсгал засварын зардал | 22,214,000.00 | 22,209,000.00 | (5,000.00) | 0.0 |
| 34 | Бусад зардал | 2,914,500.00 | 2,914,500.00 | - | 0.0 |
| 35 | Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 8,498,900.00 | 8,470,468.00 | (28,432.00) | -0.3 |
| 36 | Өрх гэрт олгох шилжүүлэг | - | - | - | - |
| 37 | Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 8,498,900.00 | 8,470,468.00 | (28,432.00) | -0.3 |

## Зочид буудал, Дэн буудлын зөвшөөрөл авахад бүрдүүлэх материал

1. **Байгууллага**-Зөвшөөрөл хүссэн албан бичиг /Гарын үсгэн дээр тамга дарсан байх/
   **Иргэн** - Зөвшөөрөл хүссэн албан хүсэлт-гарын үсэг зурсан байх
   a. Хаяг тодорхой байх
   b. Холбоо барих хүний овог нэр, утас, цахим хаягийг тодорхой бичих
   c. Албан бичиг, албан хүсэлтийн огноог НАЖГ-т материал хүлээлгэж өгсөн өдрөөр бичих
2. Зөвшөөрөл хүсэгч байгууллагын гэрчилгээ, иргэний үнэмлэх
3. Үйлчилгээний барилга байгууламж ашиглалтад хүлээн авсан тухай улсын комиссын акт, Мэргэжлийн хяналтын барилгын байцаагчийн дүгнэлт
4. Галын аюулгүй байдлыг хангах онцгой байдлын дүгнэлт /Хугацаа дуусаагүй байх, дуусах хугацаа сараас доошгүй байх/
5. Аттестатчилалд хамрагдсан баримт
6. Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх гэрчилгээ
7. Нийтийн орон сууцанд үйл ажиллагаа эрхэлдэг бол байрны /орцны/ иргэдийн гарын үсэг, СӨХ-ийн бичиг
8. Зураг тайлбартай – Жагсаалтыг хавсаргав. /Өнгөтөөр А4 цаасан дээр хэвлүүлэх/
9. Холбоо барих: Зочид буудал, дэн буудлын зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн С.Туул 8886-8805 Ажил 7010-8687
10. Зөвшөөрлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө материалаа бүрдүүлж өгөх
11. Материалыг эх хувь, хуулбар хувийн хамт авчрах

Жич: Материалыг хүлээн авсанаас хойш ажлын 15 өдрийн дотор шийдвэрлэнэ. Аттестатчилалд тэнцээгүй болон шинээр шалгуулах шаардлагатай газруудын шийдвэрлэх хугацаа сунгагдана.

**Аж ахуйн нэгж, Иргэдээс авах зургийн жагсаалт**

| | |
|---|---|
| **Барилгыг бүхлээр нь авсан зураг** | |
| 1. Галын аюулгүйн таних тэмдэг бүхий авaарын гарцны схем зургийг өрөө болгоны хаалганы дотор талд байрлуулсан байх.<br>2. Галын хор байрлуулсан байрлалын зураг<br>3. Гарцны зураг коридор урсгалд байрлуулсан байх<br>4. Зочин угтан авах хэсгийн заал | |
| Зочны өрөө ангилалтай бол ангилал тус бүрээс нэг өрөө сонгон авч өрөөний доторхи тохижилтын бүх зураг. | |
| **Зочны өрөөн дотор дараахи эд зүйлс байх шаардлагатай** | |
| 1. Ширээ сандал | 7. Ор, цагаан хэрэгслийг хийсэн байх |
| 2. Орноос тохируулах боломжтой гэрэл | 8. Нэг удаагийн хэрэгслүүд, бэлгэвч |
| 3. Зочны тоогоор шилэн аяга | 9. Зочны тоогоор нэг удаагийн шаахай |
| 4. Тагтай хогийн сав нэг удаагийн уутай | 10. Гутал өнгөлөгч |
| 5. Эд зүйлс хадгалах шүүгээ | 11. Хувцасны шүүгээ болон мөр өлгүүр, өлгүүр |
| 6. Гутлын шүүгээ болон гутлын тавиур | |
| **Зочны өрөөний ариун цэврийн өрөөний зураг** | |
| 1. Дүш болон шүршүүрийн зураг | 6. Тагтай нэг удаагийн уутай хогийн сав |
| 2. Толь, хэрэгсэл тавих тавиур, ам зайлах аяга | 7. 220 в залгуур |
| 3. Ус тусгаарлах хөшиг болон шилэн хаалт | 8. Сандал болон резинэн улавч |
| 4 Шалавч | 9 ОО цаас тогтоогч, цаас |
| 5. Жорлон | |
| **Угаалгын өрөөг бүхэлд нь авсан зураг** | |
| 1. Угаалгын машин | 4. Хатаагч |
| 2. Индүүдлэг | 5. Цагаан хэрэглэлийн хадгалалт |
| 3. Бохир, цэвэр зөөвөрлөдөг сав | |
| **Ажилчдын амралтын болон хоолны өрөө** | |
| **Ачаа тээш хадгалах өрөө** | |